



**НИЙСЛЭЛИЙН  
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/SD

Улаанбаатар хот

**「Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний  
бүртгэлийн санд өөрчлөлт оруулах журамд  
нэмэлт өөрчлөлт оруулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/817 дугаар захирамжаар батлагдсан Нийтийн Тээврийн Үйлчилгээний газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар батлагдсан “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд өөрчлөлт оруулах журам”-ын 4 дүгээр хэсэгт “Автотээврийн хэрэгсэл, жолоочийг бүртгэлийн сангаас хасах,” гэсний дараа “шаардлагатай тохиолдолд нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллахыг түр хязгаарлах” гэж нэмж өөрчлөх, “4.2.7. Шаардлагатай тохиолдолд жолоочийг Автотээврийн Хяналтын Улсын байцаагчийн тодорхойлсноор нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллахыг түр хязгаарлах” гэж нэмсүгэй.

2. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан байгууллагын цахим хуудсанд байршуулан хэрэгжилтийг ханган ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Ц.Наранцэцэг/-т, Тээврийн хяналтын хэлтэс /З.Цэвээндорж/-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч даргын үүрэг гүйцэтгэгч /Б.Эрдэнэболд/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



С.САЙХАНБАЯР